



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дүгээр зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.7, дах заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дох заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар Компанийн энгийн хувьцааг нэмж гаргасан асуудлыг танилцуулж, дор дурдсан асуудлыг хэлэлцэн батлуулахаар шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - (i) Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх,
 - (ii) Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх,
 - (iii) Компанийн энгийн хувьцааг нэмж гаргах, өрийн хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх,
 - (iv) Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх,
 - (v) Компанийн оноосон нэрийг өөрчлөх,
 - (vi) Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах,
 - (vii) ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.
3. Хурлын зарыг 2023 оны 10-р сарын 30-ны өдөр, давтан зарыг 2023 оны 11-р сарын 14-ний өдөр тус тус өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
4. Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөр тогтсугай.
6. Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
 - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол,
 - (ii) Хурлын зар,
 - (iii) Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл,
 - (iv) Хувьцааг нэмж гаргах, өрийн хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх тухай мэдээлэл,
 - (v) Өрийг хувьцаагаар солих журмын төсөл,
 - (vi) Нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл,
 - (vii) ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга,

- (viii) Хурлын саналын хуудасны загвар, болон
 - (ix) Хуралд урьдчилан цахимаар санал өгөх заавар
7. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Ганхуягийг томилсугай.
 8. Дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - (i) Д.Бүдханд, Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер (дарга),
 - (ii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, болон
 - (iii) Г.Батбаатар, Маркетингийн газрын захирал.
 9. Дор дурдсан нэр бүхий хүмүүсийг Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - (i) Б.Эрдэнэцэцэг, Голомт Капитал ҮЦК-ийн Харилцагчийн үйлчилгээний ахлах (дарга),
 - (ii) Н.Халиунгоо, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер,
 - (iii) А.Намуун, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч.
 10. Хурлын материалыг 2023 оны 10-р сарын 27-ны өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ҮЦК ХХК болон Апекс Капитал ҮЦК ХХК-д хүргүүлсүгэй.
 11. Хуралд урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээсний үндсэн дээр дээрх өдрүүдэд цахимаар хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.
 12. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
 13. Хурлын мэдэгдлийг 2023 оны 10-р сарын 27-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)



		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А. ГАНХУЯГ УЛААНБААТАР ХОТ 9022010245 6165804 ШЖР0471			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А. ГАНБОЛД			
	Г. БАТ-ЭРДЭНЭ			
	З. УЯНГА			
	Г. ЧИНЗОРИГ			
	Б. БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Ө. ЭРДЭНЭЧИМЭГ			
	В. ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
Тогтоолын батлагдсан хувь:				

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ

Хэрэв та Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани") дах бүх хувьцаагаа худалдсан буюу шилжүүлсэн бол энэхүү хурлын материалыг худалдан авагч, шилжүүлэн авагчид эсвэл холбогдох брокерт нь хүлээлгэн өгнө үү.

Хэрэв танд энэхүү хурлын материалын талаар эсвэл хэрхэн хуралд оролцож санал өгөх талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол өөрийн брокерт эсвэл 8610-6181, gantulga.t@cumongol.mn-д хандан мэдээлэл авна уу.

Хэрэв танд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэлт тайлбар шаардлагатай бол Голомт Капитал ҮЦК ХХК-ийн 99021405 утсаар эсвэл erdenetsetseg@golomtcapital.com цахим шуудангаар мэдээлэл авна уу.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 01-ний өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хүрэлцэн ирж хурлыг зарлан хуралдуулах тухай Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 29 тоот тогтоол, хурлын зар, хурлын саналын хуудас, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон бусад холбогдох материалтай танилцах боломжтой.



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК
(Хувьцааны код: CUMN)

КОМПАНИЙН ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ,
КОМПАНИЙН НЭМЖ ГАРГАХ ЭНГИЙН ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ
ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ,
КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАХ, ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ, НЭМЖ
ГАРГАСАН ХУВЬЦААГ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭЗЭМШҮҮЛЭХ,
КОМПАНИЙН ОРШИН БАЙГАА ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ,
КОМПАНИЙН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ,
КОМПАНИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ БАТЛАХ,
КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

2023 оны 12-р сарын 04-ний өдөр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр нь 2023 оны 11-р сарын 14-ний өдөр байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээнэ. Хурлын санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл урьдчилан цахимаар эсвэл хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна. Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын санал хураалтад хүчинтэй байна.

АГУУЛГА

		Хуудас
1.	Танилцуулга	3
2.	Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх	3
3.	Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх	3
4.	Компанийн энгийн хувьцааг нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх	3
5.	Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх	4
6.	Компанийн оноосон нэрийг өөрчлөх	4
7.	Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах	4
8.	ТУЗ-ийн гишүүдийг томилох	4
9.	Хурал, хурлын дэг	6
10.	Санал хураалт	7
Хавсралт 1	— Компанийн энгийн хувьцааг нэмж гарган хаалттай хүрээнд эзэмшүүлэх тухай	8
Хавсралт 2	— Өрийг хувьцаагаар солих журмын төсөл	11
Хавсралт 3	— Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл	14
Хавсралт 4	— Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга	21
Хавсралт 5	— Хурлын зар	23
Хавсралт 6	— Хурлаас гарах шийдвэрийн төсөл	25
Хавсралт 7	— Саналын хуудасны загвар	30
Хавсралт 8	— Хуралд оролцохоор бүртгүүлэх, цахимаар санал өгөх заавар	33
Хавсралт 9	— Тооллогын комиссын танилцуулга	35
Хавсралт 10	— Хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол	36

1. ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын холбогдох заалтуудыг баримтлал болгон ТУЗ нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)-ыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд хуралдуулж Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх, Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх, Компанийн энгийн хувьцааг нэмж гарган хаалттай хүрээнд эзэмшүүлэх, Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх, Компанийн оноосон нэрийг өөрчлөх, Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох асуудлыг хэлэлцэн батлуулахаар шийдвэрлэсэн.

Хурлын зарыг энэ Хурлын материалын Хавсралт 5, Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 29 тоот тогтоолыг Хавсралт 10-с тус тус харна уу.

2. КОМПАНИЙН ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Компанид дунд болон урт хугацаанд стратегийн түвшинд хамтран ажиллах хөрөнгө оруулагч нар нэмэгдэж, бизнесийн хувьд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзсэн тул Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дэх заалтын дагуу Компанийн зарласан энгийн хувьцааныхаа тоог 264,492,441 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр санал оруулж байна.

Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 1 дэх асуудал бөгөөд тус асуудлыг хэлэлцэн Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт 6-с харна уу.

3. КОМПАНИЙН НЭМЖ ГАРГАХ ЭНГИЙН ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХГҮЙ БАЙХ

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалтын дагуу Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргах энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

Компани нь өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагад үндэслэн 296,483,391 ширхэг зарласан энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагч нарт нэмж гаргах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах зорилгоор Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дах заалтын дагуу Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх саналыг оруулж байна.

Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 2 дох асуудал бөгөөд тус асуудлыг хэлэлцэн Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт 6-с харна уу.

4. КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАХ, ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ, НЭМЖ ГАРГАСАН ХУВЬЦААГ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭЗЭМШҮҮЛЭХ

Компани нь бизнесийн хувьд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дунд болон урт хугацаанд стратегийн түвшинд хамтран ажиллах хөрөнгө оруулагч нарт хувьцаа гаргаж хаалттай хүрээнд эзэмшүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2

дэх заалтын дагуу 296,483,391 ширхэг энгийн хувьцааг гарган нэгж бүрийг нь 208 төгрөгөөр худалдан нийт 61,668,545,328 төгрөгийн хөрөнгө оруулалтыг эд хөрөнгийн эрхээр болон зээлийн өглөгөөс хувьцаанд хөрвүүлэх замаар татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Ийнхүү хувьцааг нэмж гаргаснаар Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо 296,483,391 ширхгээр нэмэгдэж, нийт гаргасан хувьцааны тоо 1,114,252,034 болсныг Компанийн Дүрэмд тусгаж холбогдох бүртгэх байгууллагуудад бүртгүүлэхээр төлөвлөөд байна.

Компанийн энгийн хувьцааг нэмж гаргах тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 3 дах асуудал бөгөөд тус асуудлын танилцуулгыг Хавсралт 1, өрийг хувьцаагаар солих журмын төслийг Хавсралт 2, эд хөрөнгийн эрхээр хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх хэлцэл, гэрээний төслийг Хавсралт 3, Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт 6-с тус тус харна уу.

5. КОМПАНИЙН ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ

Компанийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг 2022 оны 08-р сарын 22-ны өдрөөр Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт шилжүүлсэнтэй холбогдуулан Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Компанийн оршин байгаа хаягийг өөрчилж Компанийн Дүрэмд тусган улмаар холбогдох бүртгэх байгууллагуудад бүртгүүлэхээр төлөвлөөд байна.

Компанийн хаягийг өөрчлөх тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 4 дах асуудал бөгөөд тус асуудлыг хэлэлцэн Хурлаас гарах тогтоолын төслийг Хурлын материалын Хавсралт 6-с харна уу.

6. КОМПАНИЙН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

Компанийн тухай хуулийн холбогдох заалтад заасан журмын дагуу Компанийн оноосон нэрийг Премиум Нэксус ХК хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусган улмаар холбогдох бүртгэх байгууллагуудад бүртгүүлэхээр төлөвлөөд байна.

Компанийн оноосон нэрийг өөрчлөх тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 5 дах асуудал бөгөөд тус асуудлыг хэлэлцэн Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт 6-с харна уу.

7. КОМПАНИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ БАТЛАХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо, оршин байгаа хаяг болон оноосон нэрд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу тус нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг Хурлаар хэлэлцүүлж батлуулан холбогдох бүртгэх байгууллагад бүртгүүлэх юм.

Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 6 дах асуудал бөгөөд тус асуудлыг хэлэлцэн Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт 6, Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг энэ Хурлын материалын Хавсралт 3-с тус тус харна уу.

8. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ

Компанийн Дүрэмд заасны дагуу ТУЗ нь есөн гишүүнтэй, гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар заасан. ТУЗ-ийн ердийн гишүүн Очирбатын Батмөнх, ТУЗ-ийн хараат бус гишүүн Нямжавын Энхболд нар нь 2023 оны 10-р сарын 24-ний өдрөөр

чөлөөлөгдөх хүсэлт гаргасны дагуу ТУЗ-өөс Залаа-Уулын Уянга-г ТУЗ-ийн ердийн гишүүнээр, Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэгийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилсонтой холбогдуулан Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож шинэ бүрэлдэхүүнээр буюу Адилбишийн Ганхуяг, Адилбишийн Ганболд, Гансүхийн Бат-Эрдэнэ, Залаа-Уулын Уянга, Болдбаатарын Бат-Эрдэнэ, Ганболдын Чинзориг нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнд, Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг, Ванчигийн Ганзориг, Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлж сонгуулахаар санал болгож байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай асуудал нь Хурлаар хэлэлцэх 7 дох асуудал бөгөөд Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт 6, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг Хавсралт 4-с тус тус харна уу.

9. ХУРАЛ, ХУРЛЫН ДЭГ

Хурлыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд хуралдуулна.

ТУЗ-өөс Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөр тогтоосон бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийхээр тогтоосон.

Хурлыг Компанийн ТУЗ-ийн дарга А.Ганхуяг даргалах бөгөөд Компанийн Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллероор удирдуулсан Хурал зохион байгуулах комисс Хурлын зохион байгуулалтыг хариуцаж дор дурдсан дэгийн дагуу Хурлыг хуралдуулна.

Хурал эхлэхийн өмнө Тооллогын комисс Хурлын ирцийг тоолж Хурлын даргад мэдэгдэнэ. Хурлын ирц бүрдсэнээр Хурлын дарга хурлыг нээж хурал хуралдуулах дэгийг, Тооллогын комисс Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хурлын ирц болон саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлон цахимаар санал өгөх журмыг танилцуулна.

Хурлаар хэлэлцэх 1 дэх асуудал буюу Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 1 дэх асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 3 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцэх 2 дох асуудал буюу Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 2 дох асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 3 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцэх 3 дах асуудал буюу Компанийн энгийн хувьцааг нэмж гарга, өрийг хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 3 дах асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 5 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцэх 4 дэх асуудал буюу Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 4 дэх асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 3 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцэх 5 дах асуудал буюу Компанийн оноосон нэрийг өөрчлөх тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 5 дах асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 3 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцэх 6 дах асуудал буюу Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 6 дах асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 3 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцэх 7 дох асуудал буюу Компанийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, ТУЗ-ийг шинэ бүрэлдэхүүнээр сонгуулахаар нэр дэвшүүлж буй асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комиссын дарга 7 дох асуудлын санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 5 минут үргэлжилнэ.

Хурлаар хэлэлцүүлэх өөр асуудал байхгүй тул Тооллогын комисс саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулна. Хуралд оролцогчид санал хураалтын үр дүнтэй танилцсаны дараа Хурлын дарга Хурлаас гарах тогтоолыг танилцуулаад Хурлыг хаана.

Хурлын зарыг энэ Хурлын материалын Хавсралт 5, Хурлаас гарах шийдвэрийн төслийг Хавсралт 6, Хуралд оролцохоор бүртгүүлэх, цахимаар санал өгөх зааврыг Хавсралт 8-с тус тус харна уу.

10. САНАЛ ХУРААЛТ

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид Хуралд оролцох цахим бүртгэл ээ <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж баталгаажуулснаар хувьцаа эзэмшигчдийн гар утсанд санал өгөх линк, нууц кодыг илгээнэ.

Санал хураалтыг цахимаар 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хандан урьдчилан өгөх, эсвэл Хурлын үеэр цахимаар <https://hural.cumongol.mn> веб хаягаар хандан өгөх боломжтой.

Түүнчлэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид нь Хурлын хийх газар буюу Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт хүрэлцэн ирж дээрх веб хаягт хандан цахимаар санал өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн Хурлын санал хураалтад хүчинтэй байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигч нь Хурлаар хэлэлцэх асуудалд “Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” болохоо илэрхийлж харгалзах нэг нүдэнд тэмдэглэгээг хийж саналаа өгнө. Компанийн гаргасан энгийн нэг хувьцаа нэг саналын эрхтэй тэнцүү байна.

Хурлын санал хураалтыг Тооллогын комисс удирдан зохион байгуулна. Тооллогын комиссын танилцуулгыг энэ Хурлын материалын Хавсралт 9, Саналын хуудасны загварыг Хавсралт 7, Хуралд цахимаар оролцохоор бүртгүүлэх, санал өгөх зааврыг Хавсралт 8-с тус тус харна уу.

КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАН ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙ

Компанид дунд болон урт хугацаанд стратегийн түвшинд хамтран ажиллах хөрөнгө оруулагч нар нэмэгдсэн, энэ нь бизнесийн хувьд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзсэн тул Компани нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дэх заалтыг баримтлал болгон нэмж хувьцаа гаргах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр санал оруулж байна.

2023 оны 10-р сарын байдлаар Компани нь нэгж бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 31,990,950 ширхэг зарласан боловч гаргаагүй энгийн хувьцаатай бөгөөд зарласан боловч гаргаагүй энгийн хувьцааны тоог нэгж бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 264,492,441 ширхгээр нэмэгдүүлж, нийт 296,483,391 ширхэг зарласан боловч гаргаагүй энгийн хувьцаатай болох, түүнчлэн Компанийн 296,483,391 ширхэг зарласан боловч гаргаагүй энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэгж бүрийг нь 208 төгрөгөөр Компанийн стратегийн хөрөнгө оруулагчдад гаргаж нийт 61,668,545,328 төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Компани нь нийт 61,668,545,328 төгрөгийн хөрөнгө оруулалтын **(1)** 35,120,900,256 төгрөгийг өрийг хувьцаагаар солих хэлбэрээр; болон **(2)** 26,547,645,072 төгрөгийг эд хөрөнгийн эрхээр төлөх гэсэн хоёр хэлбэрээр татан төвлөрүүлэх юм. Ийнхүү Компанийн хувьцааг нэмж гаргаснаар Компанийн гаргасан хувьцааны тоо 296,483,391 ширхгээр нэмэгдэж, нийт гаргасан хувьцааны тоо 1,114,252,034 болох юм (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Компанийн шинээр зарлах болон хувьцааг хаалттай хүрээнд гаргаснаар Компанийн хувьцааны тоонд орох өөрчлөлт

Компанийн энгийн хувьцаа	Одоогийн хувьцааны тоо	Шинээр зарлах хувьцааны тоо	Хаалттай хүрээнд гаргах хувьцааны тоо	Хувьцааг хаалттай хүрээнд гаргасны дараах нийт хувьцааны тоо
Зарласан	849,759,593	264,492,441	—	1,114,252,034
Гаргасан	817,768,643	—	296,483,391	1,114,252,034

(1) ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ

Компани нь Компанийн стратегийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч Премиум Групп ХХК-тай 2023 оны 03-р сарын 17-ны өдөр байгуулсан Зээлийн гэрээний дагуу Компанийн дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх, дэлгүүрийн дэд бүтцийг өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг 30,000,000,160 төгрөгийн зээл хэлбэрээр Премиум Групп ХХК-иас татан төвлөрүүлсэн бөгөөд тус өрийг хувьцаанд хөрвүүлэх замаар хаах зорилгоор Компанийн нэгж бүр нь 208 төгрөгийн үнэ бүхий 144,230,770 ширхэг энгийн хувьцааг Премиум Групп ХХК-д энэ танилцуулгын Хавсралт 3-т заасан Өрийг хувьцаагаар солих журмын дагуу гаргана.

Компани нь 2019 онд компанийн хувьцаа эзэмшигч, стратегийн хөрөнгө оруулагч болох БиЖиЭф Ритэйл Ко., Лтд-с нийт 5,000,000,000 воны зээлийн үлдэгдэл төлбөрөөс 5,120,900,096 төгрөгт нэгж бүр нь 208 төгрөгийн үнэ бүхий 24,619,712 ширхэг энгийн хувьцааг БиЖиЭф Ритэйл Ко., Лтд-д энэ танилцуулгын Хавсралт 3-т заасан Өрийг хувьцаагаар солих журмын дагуу гаргана.

Хүснэгт 2. Өрийг хувьцаагаар солих замаар гаргах хувьцаа болон татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ

ХАВСРАЛТ 1 – КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАН ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭЗЭМШҮҮЛЭХ ТУХАЙ

Стратегийн хөрөнгө оруулагчид	Гаргах хувьцааны тоо	Нэгж хувьцааг гаргах үнэ (төгрөг)	Татан төвлөрүүлэх нийт хөрөнгө оруулалтын дүн (төгрөг)
Премиум Групп ХХК	144,230,770	208	30,000,000,160
Би Жи Эф Ритэйл Ко., Лтд.	24,619,712	208	5,120,900,096
Нийт	168,850,482	—	35,120,900,256


(2) ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙГ ХУВЬЦААГААР ХУДАЛДАН АВАХ

Премиум Групп ХХК нь Сэнтрал Экспресс төслийг 2015 онд эхлүүлж, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг 2017 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2018 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын БиЖиЭФ Ритэйл Ко., Лтд. компанийн СУ олон улсын конвниенс дэлгүүрийг Монгол Улсын жижиглэн худалдааны зах зээлд нэвтрүүлэх Мастер франчайз гэрээг байгуулахад батлан даагчаар оролцож тухайн төслийн анхны төлөвлөгөөний дагуу СУ сүлжээ дэлгүүрийг нээх санхүүжилтийг гарган ажилласан. Компанийн стратегийн хөрөнгө оруулагчид болох А.Ганхуяг, А.Ганболд, Д.Бат-Ирээдүй, А.Ганбаатар, А.Одончимэг, О.Батмөнх, Г.Бат-Эрдэнэ болон Ө.Мөнхбаяр нар нь СУ конвниенс дэлгүүрийн бизнест бүрэн итгэлтэй байгаа тул цаашдын тэлэлтэд зориулж нэмж хөрөнгө оруулах сонирхолтой байгаа бөгөөд нийт 26,547,645,072 төгрөгийн дор дурдсан эд хөрөнгийн эрхийг (Хүснэгт 4) Компанид оруулж, Компанийн хаалттай хүрээнд нэмж гаргах 127,632,909 ширхэг энгийн хувьцааг эзэмшихээр төлөвлөсөн (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Стратегийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд гаргах хувьцааны тоо болон татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ

Стратегийн хөрөнгө оруулагчид	Гаргах хувьцааны тоо	Нэгж хувьцааг гаргах үнэ (төгрөг)	Татан төвлөрүүлэх хөрөнгө оруулалтын дүн (төгрөг)
А.Ганхуяг	48,938,556	208	10,179,219,648
А.Ганболд	36,414,684	208	7,574,254,272
Д.Бат-Ирээдүй	18,235,318	208	3,792,946,144
А.Ганбаатар	6,678,836	208	1,389,197,888
А.Одончимэг	6,678,836	208	1,389,197,888
О.Батмөнх	4,007,843	208	833,631,344
Г.Бат-Эрдэнэ	4,007,843	208	833,631,344
Ө.Мөнхбаяр	2,670,993	208	555,566,544
Нийт	127,632,909	—	26,547,645,072

Хүснэгт 4. Стратегийн хөрөнгө оруулагчдаас Компанид оруулах эд хөрөнгийн эрхийн бүтэц



А.Ганхуяг, А.Ганболд, Д.Бат-Ирээдүй, А.Ганбаатар, А.Одончимэг, О.Батмөнх, Г.Бат-Эрдэнэ, Ө.Мөнхбаяр нар нь хамтран Чингис Шар Айраг ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 90 хувийг, Чингис Шар Айраг Клуб ХХК-ийг 100 хувь, Сэнтрал Коммерс ХХК-ийг 100 хувь, Сэнтрал Кофе Роүстинг ХХК-ийг 100 хувь, Стора Централ ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 66 хувийг тус тус эзэмшдэг бөгөөд компани тус бүрийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн эрхийн талаарх мэдээллийг доорх хэсгээс харна уу.

(i) Чингис Шар Айраг ХХК-ийн хувьцаагаар оруулах хөрөнгийн нийт үнэлгээ нь тухайн компанийг гуравдагч талаас худалдан авсан үнэлгээ буюу 23,900,000,000 төгрөгийн 90% буюу 21,510,000,304 төгрөг болно. Чингис Шар Айраг ХХК нь 1997 онд үүсгэн байгуулагдаж Монгол Улсын шар айраг үйлдвэрлэлийн салбарт “Чингис Шар Айраг” брэндийг амжилттайгаар таниулсан үндэсний шилдэг аж ахуйн нэгжийн нэг юм. Европ дах чанартай түүхий эдийн найдвартай ханган нийлүүлэгч нартай он удаан жилийн туршид хамтарч ажилладаг тул пилснер буюу зөөлөн төрлийн шар айргийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэж борлуулдаг. Чингис Шар Айраг ХХК нь жилд 1 сая литр шар айргийг үйлдвэрлэж нийлүүлэх хүчин чадалтай ажиллаж байна.

(ii) Чингис Шар Айраг Клуб ХХК нь Чингис Шар Айраг ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани ба тухайн компанийн үнэлгээ нь тайлбар (i) дэх нийт үнэлгээний дүнд багтсан болно. Чингис Шар Айраг Клуб ХХК нь Улаанбаатар хот дах нийтийн хоолны үйлчилгээний салбарт олон жил үйл ажиллагаа явуулсан.

(iii) Сэнтрал Коммерс ХХК-ийн хувьцаагаар оруулах хөрөнгийн нийт үнэлгээ нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн дансны үнийн 100 хувь буюу 2,035,969,520 төгрөг болно. Сэнтрал Коммерс нь 2022 онд үүсгэн байгуулагдсан ба гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох шар айраг, кофений үр болон чихрэн бүтээгдэхүүнийг импортлох үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. 2023 оны 7-р сараас эхлэн Асахи (Asahi) шар айргийг импортлох албан ёсны эрхийг хүлээн авсан.

(iv) Сэнтрал Кофе Роүстинг ХХК-ийн хувьцаагаар оруулах хөрөнгийн нийт үнэлгээ нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн дансны үнийн 100 хувь буюу 1,867,432,736 төгрөг болно. Сэнтрал Кофе Роүстинг ХХК нь 2023 онд үүсгэн байгуулагдсан. Сэнтрал Кофе Роүстинг ХХК нь СУ сүлжээ дэлгүүрүүдэд хуурсан кофены үр нийлүүлэх болон хэрэглэгчдэд шууд хэрэглэх боломжтой савласан бүтээгдэхүүнийг нийлүүлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

(v) Стора Централ ХХК-ийн хувьцаагаар оруулах хөрөнгийн нийт үнэлгээ нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн дансны үнийн 66 хувь буюу 1,134,242,512 төгрөг болно. Стора Централ ХХК нь хэрэглэгчдэд өөрийн онлайн худалдааны платформоор дамжуулан өргөн хүрээний бараа бүтээгдэхүүнээс сонгон худалдан авах боломжийг олгодог. Стора Централ ХХК нь дэлхийд онлайн худалдааны салбарт тэргүүлэгч Амазоны бараа материалын удирдлагыг ашиглан гадаад улсаас захиалсан бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн хүссэн СУ сүлжээ дэлгүүрийн салбарт хүргэж ажилладаг.

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ЖУРМЫН ТӨСӨЛ**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү Компанийн өрийг хувьцаагаар солих төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийн зорилго нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (цаашид “Компани” гэх)-ийн өрийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид “МХБ” гэх)-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам, бусад холбогдох журамд заасны дагуу Компанийн өрийг Компанийн хувьцаанд хөрвүүлэх, түүнтэй холбогдон хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах, СЗХ болон МХБ-ийн үнэт цаасны бүрдүүлбэрт холбогдох өөрчлөлт оруулах, өрийг хувьцаагаар солихтой холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ажиллагааг зохион байгуулахад оршино.
- 1.2. Өрийг хувьцаагаар солих эрх зүйн үндэслэл:
- Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.7 дугаар хэсэгт тус тус зааснаар Компанийн эрх барих дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар өрийг хувьцаагаар солих тухай шийдвэрлэнэ хэмээн заасан нь Компанийн өрийг хувьцаагаар солих эрх зүйн үндэслэл болно.
- Компанийн өр гэдэгт энэхүү төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заагдсан Премиум Групп ХХК (цаашид “Зээлдэгч 1” гэх) болон БиЖиЭФ Ритэйл Ко., Лтд. (цаашид “Зээлдэгч 2” гэх)-иас хүчин төгөлдөр Зээлийн гэрээний үндсэн дээр авсан зээлийн дүнгийн үлдэгдлийг ойлгоно.
- 1.3. Оролцогч талуудын мэдээлэл:
- | | |
|----------------------|--|
| Зээлдүүлэгч 1 | Премиум Групп ХХК (“Премиум Групп”), 5476992, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Шангри-ла оффис, 23 давхар; |
| Зээлдүүлэгч 2 | БиЖиЭФ Ритэйл Ко., Лтд (“БиЖиЭф Ритэйл”) (BGF Retail Co., Ltd.), 893-88-00792, Бүгд Найрамдах Солонгос Улс, Сөүл хот, Гангнам-гү, Тэхэран-рү 405, 11-р давхар; |
| Зээлдэгч | Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”), 6155804, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж, 31, Далай Тауэр, 11 давхар. |

ХОЁР. ХУВЬЦААНД ХӨРВҮҮЛЭХ ӨР, ХӨРВҮҮЛЭХ ХЭЛБЭР

- 2.1. Компани нь дор дурдсан Хувьцаа эзэмшигчдийн өрийг 2023 оны 12-р сарын 03-ны өдрөөр тасалбар болгон хувьцаанд хөрвүүлэх зорилгоор энгийн хувьцаа нэмж зарлан, гаргана. Үүнд:
- (i) Энэхүү төслийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасан Премиум Группээс авсан Зээлийн үлдэгдэл дүн болох 30,000,000,160 төгрөгийн өрийг нэгж бүр нь 208 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 144,230,770 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэх; болон
 - (ii) Энэхүү төслийн 3 дугаар зүйлийн 4.1-т заасан БиЖиЭФ Ритэйлээс авсан Зээлийн үлдэгдэл дүн болох 5,120,900,096 төгрөгийн өрийг нэгж бүр нь 208 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 24,619,712 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэх.
- 2.2. Дээр заасан 2.1 дэх хэсэгт заасан хувьцаанд хөрвүүлэх Хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн өрийн дагуу Компани нь нэгж бүр нь 208 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 168,850,482 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Премиум Групп болон БиЖиЭф Ритэйл нарын нийт 35,120,900,256 төгрөгийн зээлийн өрийг хаана.

ГУРАВ. ПРЕМИУМ ГРУППИЙН ЗЭЭЛ

- 3.1. Зээлийн гэрээ, ер үүссэн шалтгаан. Компани нь 2023 оны 03-р сарын 17-ны өдөр Премиум Групптэй Зээлийн гэрээ байгуулж тус гэрээгээр 30,000,000,160 төгрөгийг хүүгүйгээр, үе шаттайгаар СУ конвиниенс сүлжээ дэлгүүрийн тоог нэмэх, тус дэлгүүрийн дэд бүтцийг өргөжүүлэхээр татан төвлөрүүлсэн.

ДӨРӨВ. БИЖИЭФ РИТЭЙЛИЙН ЗЭЭЛ

- 4.1. Зээлийн гэрээ, ер үүссэн шалтгаан. Компани нь 2020 оны 09-р сарын 15-ны өдөр БиЖиЭф Ритэйлтэй Зээлийн гэрээ байгуулж тус гэрээгээр Компани нь СУ конвиниенс сүлжээ дэлгүүрийг өргөжүүлэн тэлэх зориулалттайгаар, зээлдүүлэгч болох БиЖиЭф Ритэйлээс 5,000,000,000 Солонгосын воныг жилийн 4.6 хувийн хүүтэй, 7 жилийн хугацаатайгаар зээлэхээр харилцан тохиролцсон. Гэрээний талууд 2021 оны 06-р сарын 08-ны өдөр уг зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт гэрээг байгуулах өдрийн байдлаар Компани нь 4,000,000,000 воныг БиЖиЭф Ритэйлээс зээлсэн байна. Нэмэлт гэрээгээр зээлийн дүнгээс 1,985,762,188 вонд тооцож Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн хувьцааг авах, үлдэгдэл 3,014,237,812 воныг Компани нь зээлийн гэрээний хугацаанд төлөхөөр талууд харилцан тохиролцсон.

ТАВ. ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ШААРДЛАГА, НӨХЦӨЛ

- 5.1. Өрийг хувьцаагаар солих шаардлага. 2023 оны 2-р хагас жилийн санхүүгийн гүйцэтгэлээр Компани цэвэр ашгийн түвшинд төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй 19.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан ч дунд хугацааны стратегийн гол зорилтуудаа хэрэгжүүлж, цаашид ч энэ стратегиа хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Үүнд:

- Зах зээлд давамгайлах,
- Түгээлтийн дэд бүтэц, хоолны үйлдвэр, мэдээллийн технологийн цогц системийг агуулсан дэд бүтцийг бий болгох,
- Бүтээгдэхүүнээр ялгарах,
- Үнэнч хэрэглэгчийг өсгөх,
- Технологийн дэвшилд тулгуурласан борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх.

Компанийн богино хугацааны алдагдлыг санхүүжүүлэх, урт хугацааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах зарим хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор өрийг хувьцаанд хөрвүүлэх шаардлага үүссэн. Өрийг хувьцаанд хөрвүүлснээр байгууллагын ер болон өмчийн харьцааны үзүүлэлт сайжирч, зээлжих зэрэглэл нэмэгдэх давуу талтай.

- 5.2. Өрийг хувьцаагаар солих нэгж хувьцааны үнэ тогтоосон үндэслэл. Өрийг хувьцаагаар солих нэгж хувьцааны үнэ тогтоосон үндэслэл: Нэгж хувьцааны үнийг 208 төгрөгөөр тогтоосон. Энэ нь сүүлийн 6 сарын хувьцааны арилжааны дундаж үнээс 33 хувиар өндөр хэдий ч Компанийн өрсөлдөх чадвар, ирээдүйн мөнгөн урсгал зэргийг харгалзан тооцож 208 төгрөгийг өрийг хувьцаагаар солих зах зээлийн үнэ гэж үзсэн.
- 5.3. Компанийн хувьцааны мэдээлэл. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо 849,759,593 ширхэг, гаргасан энгийн хувьцааны тоо 817,768,643 байна.
- 5.4. Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлаар Компанийн гаргасан хувьцааны тоо 168,850,482 ширхгээр нэмэгдсэнийг Компанийн Дүрэмд тусгана.

ЗУРГАА. ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 6.1. Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дах хэсэгт заасны дагуу Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

- 6.2. Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 63 дугаар зүйлийн 63.7-д заасны дагуу Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
- 6.3. СЗХ-ноос хаалттай хүрээнд нэмж хувьцаа гарган Компанийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсөн шийдвэр гарсан өдрөөс эхлэн төсөл бүрэн хэрэгжиж, Компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэр, Дүрэмд орсон өөрчлөлтүүдийг зохих зөвшөөрөл, журмын дагуу бүртгүүлснээр Компанийн өрийг хувьцаагаар солих ажиллагаа хэрэгжиж дууссанд тооцно.

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭСПРЕМИУМ НЭКСУС
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан **Сэнтрал Экспресс Си Ви ЭеПремииум Нэксус** ХК (“Компани”) нь Монгол Улсын Компанийн тухай хууль (“Компанийн тухай хууль”) -д заасны дагуу өөрийн дүрэм (“Дүрэм”) -ийг батлав.
- 1.2. Энэхүү Дүрмийг батлах, түүний хүчин төгөлдөр байдал, хэрэгжүүлэлт, нэмэлт өөрчлөлт оруулах, түүний заалтууд хүчин төгөлдөр бус болох асуудал Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулагдана.
- 1.3. Энэхүү Дүрэм болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх) -өөс баталсан аливаа журмаар тусгайлан зохицуулаагүй харилцааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

- 2.1. Компанийн оноосон нэр нь монгол хэлээр **Сэнтрал Экспресс Си Ви ЭеПремииум Нэксус** ХК, англи хэлээр **Central Express CVSPremium Nexus** JSC байна.
- 2.2. Компани нь Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхар Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хөрөө, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхар -хаягт байрлана.
- 2.3. Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлгэдэл (эмблем) болон барааны тэмдэгтэй байж болно.
- 2.4. Компани нь өөрийн нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг (тамга) хэрэглэнэ.
- 2.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

- 3.1. Компани нь Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна.
- 3.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хувьцаат компани хэлбэрээр ажиллана.
- 3.3. Компани нь өөрийн нэрийн өмнөөс Монгол Улсын болон гадаадын хуулийн этгээд, хувь хүнтэй гэрээ, хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх олж авах, захиран зарцуулах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.
- 3.4. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 3.5. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дах заалтад зааснаас бусад тохиолдолд Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй, хувьцаа эзэмшигчид нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 3.6. Компани нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газраа байгуулж болно.

- 3.7. Компани нь өөрийн ~~Сентрал Экспресс Си Ви Ээ~~Премиум Нэксус ХК болон ~~Central Express CVSPremium Nexus~~ JSC гэсэн нэрийг бүх үйл ажиллагаандаа ашиглана.
- 3.8. Компани нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хуульд нийцүүлэн, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (International Financial Reporting Standards)-д заасны дагуу нарийвчилсан нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 3.9. Компани нь дотоод, гадаадын банканд төгрөг болон гадаад валютын данстай байна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 4.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:
- 4.1.1. хүнсний дэлгүүр;
 - 4.1.2. хүнсний үйлдвэрлэл;
 - 4.1.3. худалдааны зуучлал;
 - 4.1.4. франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах;
 - 4.1.5. гадаад худалдаа;
 - 4.1.6. менежментийн зөвлөх үйлчилгээ; болон
 - 4.1.7. хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.

ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

- 5.1. Компанийн зарласан энгийн хувьцаа нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ~~1,114,252,034,849,759,593~~ (найман зуун дөчин өсөн сая долоон зуун тавин өсөн мянга таван зуун ерэн гуравнэг тэрбум нэг зуун арван нэгэндөрвөн сая хоёр зуун тавин хоёр мянга гучин дөрвөн) ширхэг байна.
- 5.2. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо ~~1,114,252,034~~ (нэг тэрбум нэг зуун арван нэгэндөрвөн сая хоёр зуун тавин хоёр мянга гучин дөрвөн) ~~817,768,643~~ (найман зуун арван долоон сая долоон зуун жаран найман мянга зургаан зуун дөчин гурван) ширхэг энгийн хувьцаа байна.
- 5.3. Компанийн энгийн хувьцаа тус бүр 1 (нэг) саналын эрхтэй байна.
- 5.4. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дох хэсэгт зааснаар тодорхойлно.
- 5.5. Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, Дүрэмд зааснаас бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 5.6. Компани нь өөрийн хувьцаа болон үнэт цаасны хадгаламж, үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 6.1.1. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
 - 6.1.2. эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
 - 6.1.3. Компанийн талаарх холбогдох мэдээллийг авах, санхүүгийн болон бусад холбогдох баримт бичигтэй танилцах;

- 6.1.4. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 6.1.5. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах;
- 6.1.6. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дах заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх;
- 6.1.7. Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх; болон
- 6.1.8. Хууль тогтоомж болон энэхүү Дүрмээр тогтоосон эрх, үүрэг.

ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 7.3. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг Компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-өөс баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журамд заасны дагуу зарлан хуралдуулна.
- 8.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-өөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гаргана.
- 8.3. Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:
 - 8.3.1. энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
 - 8.3.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;
 - 8.3.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 8.3.4. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 8.3.5. ТУЗ-ийн гишүүдийг томилох, бүрэн эрхийг тогтоох болон хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 8.3.6. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 8.3.7. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан; болон
 - 8.3.8. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ТУЗ болон Гүйцэтгэх захирлаас оруулсан бусад асуудал.
- 8.4. Дүрмийн 8.3.1-8.3.4 дүгээр зүйлд заасан асуудлаар гарах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын дэмжсэн саналаар, бусад асуудлаар гарах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын дэмжсэн саналаар хүчин төгөлдөр болно.

- 8.5. Дүрмийн 8.3.5 дугаар зүйлд заасан асуудлыг Дүрмийн 9.1 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийг хурлын тэмдэглэл, тогтоол хэлбэрээр гаргаж хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд, тэдгээрийг Компанийн архивд хадгална.
- 8.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 9.1. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 (есөн) гишүүнтэй байх ба гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болно.
- 9.2. ТУЗ-ийн даргыг гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын түр эзгүйд үүргийг нь түүний томилсон, эсхүл ТУЗ-өөс тухайн удаад сонгогдсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ. ТУЗ-ийн дарга нь Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.
- 9.3. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 (гурван) жил байна.
- 9.4. ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан болон дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 9.4.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - 9.4.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 9.4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 9.4.4. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 9.4.5. Дүрэмд заасан хувьцаанд хамаарах үнэт цаас болон бусад үнэт цаас, өрийн бичиг гаргах;
 - 9.4.6. Компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 9.4.7. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
 - 9.4.8. ТУЗ, Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - 9.4.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 9.4.10. Компанийн жилийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж батлах;
 - 9.4.11. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 9.4.12. ногдол ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах журмыг тодорхойлох;
 - 9.4.13. Компанийн охин, хараат компани, салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, тэдгээрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

- 9.4.14. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох;
- 9.4.15. Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
- 9.4.16. Компанийн үндсэн хөрөнгийг актлах, данснаас хасах, худалдах, шилжүүлэх, хөрөнгийн үнэлгээний дүнгээр үнэ цэний бууралтыг бүртгэх, хүлээн зөвшөөрөх асуудлыг шийдвэрлэх;
- 9.4.17. Компанийн өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 9.4.18. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 9.4.19. Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалтад заасан тайлан;
- 9.4.20. энэ Дүрэм болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон асуудал; болон
- 9.4.21. гүйцэтгэх удирдлагын саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 9.5. ТУЗ үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах бөгөөд үүнд ТУЗ-ийн хурлыг хуралдуулах журмыг мөн заасан байна.
- 9.6. ТУЗ-ийн хурлыг улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа хуралдуулах, шаардлагатай тохиолдолд хэдийд ч ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулж болох бөгөөд ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонх зөвшөөрч гарын үсэг зурснаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 9.7. ТУЗ-ийн хурлыг телефон утас, видеофон буюу түүнтэй адилтгах холбооны хэрэгслээр цахим хэлбэрээр хуралдуулж болно. Ийнхүү хуралдсан хурлыг биечлэн хуралдсанд тооцно.
- 9.8. ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж оролцох эрхтэй бөгөөд тухайн итгэмжлэгдсэн төлөөлөгч итгэмжлэл олгосон этгээдийн өмнөөс ТУЗ-ийн хуралд оролцох болон санал өгөхийг зөвшөөрнө.
- 9.9. ТУЗ нь Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой байх ба хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 9.10. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
- 9.11. ТУЗ-ийн хороодын чиг үүргийг ТУЗ-өөс баталсан журмаар тодорхойлох ба ТУЗ-ын хороод нь тодорхой асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.
- 9.12. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилох ба ТУЗ-ын дарга нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.
- 9.13. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-өөс баталсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үүргийг хүлээнэ.

АРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 10.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Компанийн Гүйцэтгэх захирал энэ Дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгогдсон эсвэл ТУЗ-өөс тусгайлан олгосон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

- 10.2. Гүйцэтгэх захиралд олгогдсон эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэргийг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заана.
- 10.3. Гүйцэтгэх захирал өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлыг шийдвэрлэх, эрх олгох, хэлцэл хийх, гэрээ байгуулах, Компанийн ажиллагсдыг ажилд томилох, чөлөөлөх, ажилтны ажлын байрын тодорхойлолтыг батлах, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, Компанийг төрийн байгууллагын өмнө төлөөлөх зэрэг компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 10.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

- 11.1. Дараах албан тушаалтнууд нь Компанийн эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд:
- 11.1.1. ТУЗ-ийн гишүүд;
- 11.1.2. Гүйцэтгэх захирал;
- 11.1.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; болон
- 11.1.4. ТУЗ-өөс эрх бүхий албан тушаалтнаар тооцсон бусад этгээд.
- 11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ТУЗ эсвэл Компанитай байгуулсан гэрээнд заасан эрх эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

АРВАН ХОЁР. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

- 12.1. Их хэмжээний хэлцэлд Компанийн тухай хуулийн 87.1-д заасан хэлцлийг тооцно.
- 12.2. Их хэмжээний хэлцэлд Компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл хамаарахгүй.
- 12.3. Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.
- 12.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан этгээдтэй хийсэн хэлцлийг тооцно.
- 12.5. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуулийн 91, 92 дугаар зүйлд заасан шаардлага, журмын дагуу хийнэ.

АРВАН ГУРАВ. ТАТВАР НОГДУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 13.1. Компанийн санхүүгийн жил нь бүртгэгдсэн өдрөөс эхэлж 12-р сарын 31-ний өдөр дуусна. Компанийг татан буулгах онд санхүүгийн жил нь 01-р сарын 01-ний өдөр эхэлж татан буулгасан өдөр дуусна. Бусад онд санхүүгийн жил нь 01-р сарын 01-ний өдөр эхэлж 12-р сарын 31-ний өдөр дуусна.
- 13.2. Санхүүгийн ба нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу хөтөлж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий этгээдэд танилцуулна.
- 13.3. Компанийн хөндлөнгийн аудитын байгууллага нь Монгол улсын болон олон улсын нягтлан бодох стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий нягтлан бодогч буюу нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шаардлагаар Компанийн санхүүгийн баримт бичгийг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчлэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр хөндлөнгийн аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.

- 13.4. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдуулах аливаа татвар, төлбөрүүдийг зохих ёсоор төлнө.
- 13.5. Компанийн нягтлан бодох бүртгэлийн тайланд хийх жилийн аудитыг хөндлөнгийн аудитын байгууллага хийх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Монгол Улсын холбогдох байгууллагад гаргаж өгнө.

АРВАН ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

- 14.1. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 14.2. Компанийн ногдол ашгийн бодлого, төлөх журмыг ТУЗ батална.
- 14.3. Компанийн ногдол ашгийн бодлогыг нийтэл ил тод байршуулна.

АРВАН ТАВ. ДОТООД ХЯНАЛТ

- 15.1. Компанийн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Компанийн удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх ба үүнтэй холбогдох журмыг ТУЗ батална. Тус журам нь Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйл болон бусад холбогдох хуульд нийцсэн байна.
- 15.2. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлж ажиллах дотоод аудитыг Аудитын хороо томилж, үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангаж ажиллана.

АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

- 16.1. Компанийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр буюу шүүхийн шийдвэрийн дагуу өөрчлөн байгуулах буюу татан буулгаж болно.
- 16.2. Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу компани нийт энгийн хувьцааны 75 хувиас дээш хувийг эзэмшдэг өөрийн охин компаниа нэгтгэх, ийнхүү нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд ТУЗ уг компанийг нэгтгэх шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг баталж болно.
- 16.3. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-29 дүгээр зүйлүүдийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 16.4. Компанийг татан буулгасан тохиолдолд түүний өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр хуваарилна.
- 16.5. Компанийг өөрчлөн байгуулах буюу татан буулгах ажлыг Компанийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу гүйцэтгэнэ.

АРВАН ДОЛОО. БУСАД

- 17.1. Энэхүү Дүрмийг 2 хувь үйлдэж нэг хувийг бүртгэх байгууллагад, үлдсэн нэг хувийг Компани өөртөө хадгална.
- 17.2. Энэхүү Дүрэм нь Компани бүртгэх байгууллагад бүртгэгдэж гэрчилгээ авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 17.3. Энэхүү Дүрэм нь Компанийн эрх зүйн байдлыг тодорхойлсон үндсэн баримт бичиг байна.

-----oOo-----

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Адилбишийн Ганхуяг нь Премиум Корпорэйшн ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн дарга, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгч бөгөөд сүүлийн 20 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.

Адилбишийн Ганболд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшн ХХК-ийн үүсгэн байгуулагч, Премиум Корпорэйшн ХХК-ийн зэргэлдээ, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (“ШУТИС”)–ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.

Гансүхийн Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшн ХХК-ийн Санхүү хариуцсан захирлаар ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 20 жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

Залаа-Уулын Уянга нь Премиум Корпорэйшн ХХК-ийн Хүний нөөцийн төслийн захирал бөгөөд тэрээр хүний эрхийн чиглэлийн олон улсын байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагад хүүхэд, залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийн олон сая долларын хөтөлбөрүүдийн санхүүжилт, менежмент хариуцаж 13 жил ажилласан туршлагатай. Мөн гарааны бизнесийн экосистем хөгжүүлэх Стартап Монгол ТББ-ын Гүйцэтгэх захирал, хүний нөөцийн технологи хөгжүүлэгч Нитотех технологийн компанид Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан. Тэрээр МУИС-ийг Олон улсын харилцааны бакалаврын зэрэгтэй, Японы Токио дахь ХОУИС-ийг Төрийн удирдлагын магистрын зэрэгтэйгээр тус тус дүүргэсэн.

Ганболдын Чинзориг нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интеллиженс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар (“МТШХХГ”)–ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба

санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Болдбаатарын Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дах суурин төлөөлөгч, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 14 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад “Private Equity” болон “Venture Capital” хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр дагнан судалгаа, үнэлгээ хийдэг Когнос Интернэйшнл ХХК-ийн Захирал, үүсгэн байгуулагч бөгөөд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЮНЕСКО, Европын холбоо гэх мэт олон улсын байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөр, стратеги, Тогтвортой хөгжлийн зорилгын судалгаа, үнэлгээ дээр сүүлийн 14 жил ажиллаж байна. Тэрээр Монголын үнэлгээний холбооны үүсгэн байгуулагч, ТУЗ-ын дарга ба Америкийн үнэлгээний холбоо болон Монголын үнэлгээний холбооны Нийгмийн нөлөөллийн хэмжилт, Байгаль орчин, нийгэм, засаглалын ажлын хэсэг, Үнэлгээний хамтын ажиллагааны төлөөх олон улсын байгууллага (IOCE) болон Ази номхон далайн үнэлгээний холбоо (APEA)-ны Үнэлгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх ажлын хэсгийн гишүүнээр ажилладаг. Эрдэнэчимэг нь МУИС-д хүн амзүйн докторант ба Английн Лондоны Эдийн засгийн сургуульд нийгмийн судалгааны аргазүйн магистр, Тайландын Махидолын их сургуулиас хүн ам, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны магистр зэрэг хамгаалсан.

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн чиглэлээр дагнан судалгаа, үнэлгээ хийдэг Когнос Интернэйшнл ХХК-ийн Захирал, үүсгэн байгуулагч юм. Тэрээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЮНЕСКО, Европын холбоо гэх мэт олон улсын байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөр, стратеги мөн Тогтвортой хөгжлийн зорилгын судалгаа, үнэлгээ дээр сүүлийн 14 жил ажиллаж байна. Эрдэнэчимэг нь Монголын үнэлгээний холбооны үүсгэн байгуулагч, ТУЗ-ын дарга бөгөөд Америкийн үнэлгээний холбоо, Монголын үнэлгээний холбооны Нийгмийн нөлөөллийн хэмжилт ба Байгаль орчин, нийгэм, засаглалын салбар бүлгийн гишүүн, Үнэлгээний хамтын ажиллагааны төлөөх олон улсын байгууллага (IOCE), Ази номхон далайн үнэлгээний холбоо (APEA)-ны Үнэлгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх ажлын хэсгийн гишүүнээр тус тус ажилладаг. Эрдэнэчимэг нь МУИС-д хүн амзүйн докторант ба Английн Лондоны Эдийн Засгийн Сургуульд нийгмийн судалгааны аргазүйн магистр, Тайландын Махидолын Их Сургуульд хүн ам, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны магистр зэрэг тус тус хамгаалсан.

Ванчигийн Ганзориг нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партнерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, “CEO” клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшипийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн, Монголын Тусгай Олимпын Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, “Global Teacher Prize”-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлага нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, МОСДАК, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан. В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Даме Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монголын Улсын мэргэшсэн зөвлөх юм.

Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Улаанбаатар дах Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Жуулчин Уорлд Турс ХХК-ийн ахлах зөвлөх, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал бөгөөд Монгол дах Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дэд даргаар ажиллаж байсан. Тэрээр 30 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 29 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)–ыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд хуралдуулна.

Хурлаар Компанийн энгийн хувьцааг нэмж гаргасан асуудлыг танилцуулж, дор дурдсан асуудлыг хэлэлцэн батална. Үүнд:

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх,
2. Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх,
3. Компанийн энгийн хувьцааг нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх,
4. Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх,
5. Компанийн оноосон нэрийг өөрчлөх,
6. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах,
7. ТУЗ–ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр нь 2023 оны 11-р сарын 14-ний өдөр байна. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид нь Компанийн www.cumongol.mn вэбсайтаас, эсвэл 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 01-ний өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хүрэлцэн ирж Хурал хуралдуулахтай холбоотой баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээнэ.

Хурлын санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл урьдчилан цахимаар болон Хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна.

Хурал зохион байгуулах комиссын даргаар Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер Д.Бүдханд, гишүүдээр ТУЗ–ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга, Маркетингийн газрын захирал Г.Батбаатар нар ажиллах бөгөөд Хуралд оролцож, санал өгөхтэй холбоотой мэдээллийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 01-ний өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд 8610-6181 утсаар эсвэл gantulga.t@cumongol.mn цахим шуудангаар авах боломжтой.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: КОМПАНИЙН ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дох заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэгж бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 264,492,441 (хоёр зуун жаран дөрвөн сая дөрвөн зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун дөчин нэгэн) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж, нийт 1,114,252,034 (нэг тэрбум нэг зуун арван дөрвөн сая хоёр зуун тавин хоёр мянга гучин дөрвөн) ширхэг байхаар тогтоосугай.

2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг) нарт үүрэг болгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: КОМПАНИЙН НЭМЖ ГАРГАХ ЭНГИЙН ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХГҮЙ БАЙХ

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дах заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дах заалт, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь 296,483,391 (хоёр зуун ерэн зургаан сая дөрвөн зуун наян гурван мянга гурван зуун ерэн нэгэн) ширхэг зарласан энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад нэмж гаргахад хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Тогтоолын 1-д заасан Компанийн нийт зарласан хувьцаанаас хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, стратегийн хөрөнгө оруулагчдад эзэмшүүлэх нөхцөлийг тогтоох, эдгээртэй холбоотой бусад шийдвэрийг тухай бүр гаргах, энэхүү тогтоолыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллах эрхийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3.(А): КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАХ, ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дах заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын ___ тоот тогтоол, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 144,230,770 (нэг зуун дөчин дөрвөн сая хоёр зуун гучин мянга долоон зуун далан) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган Премиум Групп ХХК-д эзэмшүүлж, Компани Премиум Групп ХХК нарын хооронд байгуулсан Зээлийн гэрээний холбогдох заалтын дагуу 30,000,000,160 (гучин тэрбум нэг зуун жаран) төгрөгийг зээлийн өглөгөөс хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3.(Б): КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАХ, ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дах заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)-ын ___ тоот тогтоол, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 24,619,712 (хорин дөрвөн сая зургаан зуун арван есөн мянга долоон зуун арван хоёр) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган БиЖиЭф Ритэйл Ко., Лтд.-д эзэмшүүлж, Компани БиЖиЭф Ритэйл Ко., Лтд нарын хооронд байгуулсан Зээлийн гэрээний холбогдох заалтын дагуу 5,120,900,096 (таван тэрбум нэг зуун хорин сая есөн зуун мянга ерэн зургаан) төгрөгийг зээлийн өглөгөөс хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3.(В): КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ГАРГАН ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭЗЭМШҮҮЛЭХ

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 31 дүгээр зүйлийн 31.2.2, 62 дугаар зүйлийн 62.1.3 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.3 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)-ын ___ тоот тогтоол, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 48,938,556 (дөчин найман сая есөн зуун гучин найман мянга таван зуун тавин зургаан) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч А.Ганхуягт эзэмшүүлж, А.Ганхуягийн 10,179,219,648 (арван тэрбум нэг зуун далан есөн сая хоёр зуун арван есөн мянга зургаан зуун дөчин найман) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

2. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 36,414,684 (гучин зургаан сая дөрвөн зуун арван дөрвөн мянга зургаан зуун наян дөрвөн) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч А.Ганболдод эзэмшүүлж, А.Ганболдын 7,574,254,272 (долоон тэрбум таван зуун далан дөрвөн сая хоёр зуун тавин дөрвөн мянга хоёр зуун далан хоёр) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

3. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 18,235,318 (арван найман сая хоёр зуун гучин таван мянга гурван зуун арван найман) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч Д.Бат-Ирээдүйд эзэмшүүлж, Д.Бат-Ирээдүйн 3,792,946,144 (гурван тэрбум долоон зуун ерэн хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга нэг зуун дөчин дөрвөн) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

4. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 6,678,836 (зургаан сая зургаан зуун далан найман мянга найман зуун гучин зургаан) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч А.Ганбаатарт эзэмшүүлж, А.Ганбаатарын 1,389,197,888 (нэг тэрбум гурван зуун наян есөн сая нэг зуун ерэн долоон мянга найман зуун наян найман) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй. Үүнд:

5. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 6,678,836 (зургаан сая зургаан зуун далан найман мянга найман зуун гучин зургаан) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч А.Одончимэгт эзэмшүүлж, А.Одончимэгийн 1,389,197,888 (нэг тэрбум гурван зуун наян есөн сая нэг зуун ерэн долоон мянга найман зуун наян найман) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

6. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 4,007,843 (дөрвөн сая долоон мянга найман зуун дөчин гурван) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч О.Батмөнхөд эзэмшүүлж, О.Батмөнхийн 833,631,344 (найман зуун гучин гурван сая зургаан зуун гучин нэгэн мянга гурван зуун дөчин дөрвөн) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

7. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 4,007,843 (дөрвөн сая долоон мянга найман зуун дөчин гурван) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч Г.Бат-Эрдэнэд эзэмшүүлж, Г.Бат-Эрдэнэ-н 833,631,344 (найман зуун гучин гурван сая зургаан зуун гучин нэгэн мянга гурван зуун дөчин дөрвөн) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

8. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 2,670,993 (зургаан сая зургаан зуун далан найман мянга найман зуун гучин зургаан) ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг нь 208 (хоёр зуун найман) төгрөгөөр хаалттай хүрээнд нэмж гарган стратегийн хөрөнгө оруулагч Ө.Мөнхбаярт эзэмшүүлж, Ө.Мөнхбаярын 555,566,544 (таван зуун тавин таван сая таван зуун жаран зургаан мянга таван зуун дөчин дөрвөн) төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэсүгэй.

9. Компанийн стратегийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд худалдсан хувьцаанаас төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нь дор дурдсан хөрөнгөөс бүрдсэн 26,547,645,072 (хорин зургаан тэрбум таван зуун дөчин долоон сая зургаан зуун дөчин таван мянга далан хоёр) төгрөг байхаар тогтоосугай. Үүнд:

Стратегийн хөрөнгө оруулагчид	Чингис Шар Айраг ХХК, Чингис Шар Айраг Клуб ХХК	Сэнтрал Коммерс ХХК	Сэнтрал Кофе Реүстинг ХХК	Стора Централ ХХК	Нийт
А.Ганхуяг	8,133,170,032	769,596,464	705,889,392	570,563,760	10,179,219,648
А.Ганболд	6,190,099,968	585,952,016	537,447,040	260,755,248	7,574,254,272
Д.Бат-Ирээдүй	3,099,830,032	293,383,168	269,097,088	130,635,856	3,792,946,144
А.Ганбаатар	1,135,250,064	107,499,184	98,600,528	47,848,112	1,389,197,888

А.Одончимэг	1,135,250,064	107,499,184	98,600,528	47,848,112	1,389,197,888
О.Батмөнх	681,150,080	64,540,320	59,197,632	28,743,312	833,631,344
Г.Бат-Эрдэнэ	681,150,080	64,540,320	59,197,632	28,743,312	833,631,344
Ө.Мөнхбаяр	454,099,984	42,958,864	39,402,896	19,104,800	555,566,544
Нийт	21,510,000,304	2,035,969,520	1,867,432,736	1,134,242,512	26,547,645,072

10. Компани нь энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргасантай холбоотойгоор Компани нь нийт гаргасан энгийн хувьцаа 127,632,909 (нэг зуун хорин долоон сая зургаан зуун гучин хоёр мянга есөн зуун есөн) ширхгээр нэмэгдсэн болохыг үүгээр баталгаажуулсугай.

11. Энэхүү тогтоолд дурдсан эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлэн авахтай холбоотой хийгдэх аливаа гэрээ, хэлцэл, түүнтэй холбоотой бусад бүх баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.

12. Энэхүү тогтоолын хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах, холбогдох баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4: КОМПАНИЙН ОРШИН БАЙГАА ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Компанийн оршин байгаа хаягийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5: КОМПАНИЙН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оноосон нэрийг Монголоор Премиум Нэксус ХК, Англиар Premium Nexus JSC хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Компанийн оноосон нэрийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6: КОМПАНИЙГ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ДҮРМИЙН ТӨСЛИЙГ БАТЛАХ

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл (“Дүрэм”)–ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)–д үүрэг болгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 7: КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн ээлжит бус хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбишийн Ганхуяг,
 - (ii) Адилбишийн Ганболд,
 - (iii) Гансүхийн Бат-Эрдэнэ,
 - (iv) Залаа-Уулын Уянга,
 - (v) Болдбаатарын Бат-Эрдэнэ,
 - (vi) Ганболдын Чинзориг.
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг,
 - (ii) Ванчигийн Ганзориг,
 - (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)–д үүрэг болгосугай.

**СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2023 ОНЫ 12-Р САРЫН 04-НИЙ ӨДРИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувь хүний овог, нэр/Байгууллагын оноосон нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо: _____

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)–д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээнэ.

Хурлын санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл урьдчилан цахимаар болон Хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна.

Хувьцаа эзэмшигчид 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд биечлэн ирж цахимаар санал өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн Хурлын санал хураалтад хүчинтэй байна.

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ		ЗӨВШӨӨРСӨН (Санамж 1)	ТАТГАЛЗСАН (Санамж 1)	ТҮДГЭЛЗСЭН (Санамж 1)
1.	Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 264,492,441 ширхгээр нэмэгдүүлж, нийт 1,114,252,034 ширхэг байхаар тогтоосугай.			
2.	Компани нь 296,483,391 ширхэг зарласан энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад нэмж гаргахад хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж, Компанийн нийт зарласан хувьцаанаас хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, стратегийн хөрөнгө оруулагчдад эзэмшүүлэх нөхцөлийг тогтоох, эдгээртэй холбоотой бусад шийдвэрийг тухай бүр гаргах бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.			
3.(а)	Компанийн зарласан энгийн хувьцаанаас 144,230,770 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган Премиум Групп ХХК-д эзэмшүүлж, 30,000,000,160 төгрөгийг зээлийн өглөгөөс хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэж, холбогдох өрийг хувьцаагаар солих төлийг баталсугай.			
3.(б)	Компанийн зарласан энгийн хувьцаанаас 24,619,712 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган БиЖиЭф Ритэйл Ко., Лтд.-д эзэмшүүлж, 5,120,900,096 төгрөгийг			

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ		ЗӨВШӨӨРСӨН (Санамж 1)	ТАТГАЛЗСАН (Санамж 1)	ТҮДГЭЛЗСЭН (Санамж 1)																				
	зээлийн өглөгөөс хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсүгэй.																							
3.(в)	Компанийн зарласан энгийн хувьцаанаас 127,632,909 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган дор дурдсан хэмжээгээр стратегийн хөрөнгө оруулагчдад эзэмшүүлж, нийт 26,547,645,072 төгрөгийн эд хөрөнгийн эрхийг Компанид шилжүүлж авахаар шийдвэрлэж, холбогдох өрийг хувьцаагаар солих төлийг баталсугай.																							
	<table border="1"> <thead> <tr> <th>Стратегийн хөрөнгө оруулагч</th> <th>Хаалттай хүрээнд эзэмшүүлэх хувьцааны тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>А.Ганхуяг</td> <td>48,938,556</td> </tr> <tr> <td>А.Ганболд</td> <td>36,414,684</td> </tr> <tr> <td>Д.Бат-Ирээдүй</td> <td>18,235,318</td> </tr> <tr> <td>А.Ганбаатар</td> <td>6,678,836</td> </tr> <tr> <td>А.Одончимэг</td> <td>6,678,836</td> </tr> <tr> <td>О.Батмөнх</td> <td>4,007,843</td> </tr> <tr> <td>Г.Бат-Эрдэнэ</td> <td>4,007,843</td> </tr> <tr> <td>Ө.Мөнхбаяр</td> <td>2,670,993</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>127,632,909</td> </tr> </tbody> </table>	Стратегийн хөрөнгө оруулагч	Хаалттай хүрээнд эзэмшүүлэх хувьцааны тоо	А.Ганхуяг	48,938,556	А.Ганболд	36,414,684	Д.Бат-Ирээдүй	18,235,318	А.Ганбаатар	6,678,836	А.Одончимэг	6,678,836	О.Батмөнх	4,007,843	Г.Бат-Эрдэнэ	4,007,843	Ө.Мөнхбаяр	2,670,993	Нийт	127,632,909			
Стратегийн хөрөнгө оруулагч	Хаалттай хүрээнд эзэмшүүлэх хувьцааны тоо																							
А.Ганхуяг	48,938,556																							
А.Ганболд	36,414,684																							
Д.Бат-Ирээдүй	18,235,318																							
А.Ганбаатар	6,678,836																							
А.Одончимэг	6,678,836																							
О.Батмөнх	4,007,843																							
Г.Бат-Эрдэнэ	4,007,843																							
Ө.Мөнхбаяр	2,670,993																							
Нийт	127,632,909																							
4.	Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хэмээн өөрчилсүгэй.																							
5.	Компанийн оноосон нэрийг Монголоор Премиум Нэксус ХК, Англиар Premium Nexus JSC хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.																							
6.	Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг хавсралт ёсоор баталсугай.																							
<p>Санамж 1:</p> <p>“Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” ээ илэрхийлж харгалзах нэг нүдэнд <input checked="" type="checkbox"/> тэмдэглэгээг хийж санал аа өгнө.</p>																								

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ		НЭР ДЭВШИГЧИД ӨГӨХ САНАЛЫН ТОО (Санамж 2)
Дор дурдсан нэр дэвшигчдийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн ердийн гишүүдээр сонгох. Үүнд:		
7.(а)	Адилбишийн Ганхуяг	
7.(б)	Адилбишийн Ганболд	
7.(в)	Гансүхийн Бат-Эрдэнэ	
7.(г)	Залаа-Уулын Уянга	
7.(д)	Ганболдын Чинзориг	
7.(е)	Болдбаатарын Бат-Эрдэнэ	
Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгох. Үүнд:		
8.(а)	Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг	
8.(б)	Ванчигийн Ганзориг	
8.(в)	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)	

Санамж 2:

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь Компанийн Дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Тухайлбал, хувьцаа эзэмшигч А нь Компанийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн Дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-гийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй. Жишээ нь:

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно.

Хувьцаа эзэмшигчийн баталгаажуулалт:

Огноо:

ХУРАЛД ОРОЛЦОХООР БҮРТГҮҮЛЭХ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)–ыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд хуралдуулна.

2023 оны 11-р сарын 14-ний өдрийн байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд Компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэлтэй байгаа хувьцаа эзэмшигчид тус Хуралд оролцох эрхтэй байна. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэл 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл хийгдэнэ. Хувьцаа эзэмшигч нь дараах журмаар хуралд оролцохоор бүртгүүлнэ.

Компанийн хувьцаа эзэмшигч байгууллагын хувьд Хуралд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон байх шаардлагатай бөгөөд тус итгэмжлэгдсэн төлөөлөгчид холбогдох нотариатаар баталгаажсан итгэмжлэлийг олгосон байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэлийн дагуу дараах журмаар хуралд оролцохоор бүртгүүлнэ.

1. <https://hural.cumongol.mn> веб хаягт хандан орж харгалзах талбарт өөрийн дараах мэдээллийг оруулж Хуралд оролцох хүсэлт ээ илгээнэ.

- Овог, нэр;
- Регистрийн дугаар (*гадаад хувьцаа эзэмшигчийн хувьд*: паспортын дугаар);
- Утасны дугаар;
- Цахим шуудангийн хаяг;
- Иргэний үнэмлэхийн нүүр болон ар талын зураг (*16-с доош насны иргэний хувьд*: төрсний гэрчилгээний зураг, *гадаад иргэний хувьд*: паспортын зураг);
- *Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд* итгэмжлэлийн зураг.

2. Хувьцаа эзэмшигчийн илгээсэн мэдээллийг Хурал зохион байгуулах комисс Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн жагсаалттай тулган баталгаажуулна.

3. Хувьцаа эзэмшигчийн баталгаажуулалт амжилттай болсон тохиолдолд дараах мэдээлэл хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй утасны дугаарт мессежээр ирнэ.

- Бүртгэл амжилттай хийгдсэн тухай баталгаажуулалт;
- Цахим хуралд оролцох линк;
- <https://hural.cumongol.mn> веб хаягт цахимаар санал өгөхөд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг.

ХУРАЛД ЦАХИМААР САНАЛ ӨГӨХ

Цахимаар санал өгөхөд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үгийг хүлээн авсан Хувьцаа эзэмшигч дараах 3 аргаас сонгон санал өгөх боломжтой. Үүнд:

(А) Урьдчилан цахимаар санал өгөх. Хурлын урьдчилсан санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 11-р сарын 14-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл хүртэл хүлээн авна.

(Б) Хурлын үеэр цахимаар санал өгөх. Хурлын үеэр буюу 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00–16:00 цагт <https://hural.cumongol.mn> веб хаягт хандан санал өгөх.

(В) Хурлын үеээр санал өгөх. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигч нь 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39,

Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд биечлэн ирж <https://hural.cumongol.mn> веб хаягт хандан санал өгөх.

Цахимаар санал өгөхөд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үгийг хүлээн авсан Хувьцаа эзэмшигч дараах журмаар санал аа өгнө.

1. <https://hural.cumongol.mn> веб хаягт хандана.

2. Бүртгэлтэй утасны дугаарт ирсэн нэвтрэх нэр, нууц үгийг харгалзах талбарт оруулан системд нэвтэрнэ.

3. Хурлаар хэлэлцэж буй 1, 2, 3, 4, 5, 6 дах асуудал тус бүрийн харгалзах хэсэгт “Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” гэдгээ илэрхийлж аль нэгийг сонгон тэмдэглэгээг хийж санал аа өгнө.

Хурлаар хэлэлцэж буй 7 дох асуудлын хувьд санал хураалтыг кумулятив аргаар хураана. Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 хувьцаа нь 9-н саналын эрхтэй байх ба хувьцаа эзэмшигч саналын нийт эрхээ өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй. Ийнхүү санал аа өгөхдөө харгалзах талбарт саналын тоог оруулах хэлбэрээр өгнө.

4. Санал өгөх талбарын доод хэсэгт байрлах Анхааруулга хэсэгт тэмдэглэгээг хийснээр “САНАЛ ӨГӨХ” товчлуур идэвхэжнэ.

5. “САНАЛ ӨГӨХ” товчлуур дээр дарж санал аа илгээнэ.

6. Санал тоологдсоныг баталгаажуулсан цонх гарч ирнэ.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТАНИЛЦУУЛГА

Хурлын Тооллогын комиссоор Голомт Капитал ҮЦК ХХК ажиллана. Голомт Капитал ҮЦК ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, тус салбарт 2012 оноос үйл ажиллагаа явуулж буй туршлагатай компаниудын нэг юм.

Тооллогын комисс нь хурлын ирцийг тогтоож, хурлын даргад мэдээлэх, хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хурлын ирц болон саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох, санал өгөх журмыг тайлбарлах, санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай хуралд танилцуулах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх болон хуульд заасан бусад эрх үүрэгтэйгээр Хуралд оролцоно.

Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр дараах хүмүүс ажиллана. Үүнд:

1. Б.Эрдэнэцэцэг, Голомт Капитал ҮЦК-ийн Харилцагчийн үйлчилгээний ахлах (дарга),
2. Н.Халиунгоо, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер,
3. А.Намуун, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч.



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дүгээр зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.7, дах заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дох заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:











1. Хурлыг 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, Махатма Ганди гудамж 39, Корпорэйт Конвеншн Центрийн 5-р давхрын хурлын өрөөнд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар Компанийн энгийн хувьцааг нэмж гаргасан асуудлыг танилцуулж, дор дурдсан асуудлыг хэлэлцэн батлуулахаар шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - (i) Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх,
 - (ii) Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх,
 - (iii) Компанийн энгийн хувьцааг нэмж гаргах, өрийн хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх,
 - (iv) Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх,
 - (v) Компанийн оноосон нэрийг өөрчлөх,
 - (vi) Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах,
 - (vii) ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.
3. Хурлын зарыг 2023 оны 10-р сарын 30-ны өдөр, давтан зарыг 2023 оны 11-р сарын 14-ний өдөр тус тус өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
4. Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөр тогтсугай.
6. Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
 - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол,
 - (ii) Хурлын зар,
 - (iii) Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл,
 - (iv) Хувьцааг нэмж гаргах, өрийн хувьцаагаар солих, нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд эзэмшүүлэх тухай мэдээлэл,
 - (v) Өрийг хувьцаагаар солих журмын төсөл,
 - (vi) Нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл,
 - (vii) ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга,

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 29 тоот тогтоол

- (viii) Хурлын саналын хуудасны загвар, болон
 - (ix) Хуралд урьдчилан цахимаар санал өгөх заавар
7. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Ганхуягийг томилсугай.
 8. Дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - (i) Д.Бүдханд, Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер (дарга),
 - (ii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, болон
 - (iii) Г.Батбаатар, Маркетингийн газрын захирал.
 9. Дор дурдсан нэр бүхий хүмүүсийг Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - (i) Б.Эрдэнэцэцэг, Голомт Капитал ҮЦК-ийн Харилцагчийн үйлчилгээний ахлах (дарга),
 - (ii) Н.Халиунгоо, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер,
 - (iii) А.Намуун, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч.
 10. Хурлын материалыг 2023 оны 10-р сарын 27-ны өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ҮЦК ХХК болон Алекс Капитал ҮЦК ХХК-д хүргүүлсүгэй.
 11. Хуралд урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2023 оны 11-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 04-ний өдрийн 14:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээсний үндсэн дээр дээрх өдрүүдэд цахимаар хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.
 12. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
 13. Хурлын мэдэгдлийг 2023 оны 10-р сарын 27-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 29 тоот тогтоол

		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А. ГАНХУЯК <small>УЛААНБААТАР ХОТ 9022010248 6165604 ШЖР0471</small>			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А. ГАНБОЛД			
	Г. БАТ-ЭРДЭНЭ			
	З. УЯНГА			
	Г. ЧИНЗОРИГ			
	Б. БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Ө. ЭРДЭНЭЧИМЭГ			
	В. ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
Тогтоолын батлагдсан хувь:				